

ТАНИЛЦУУЛГА

Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн тухай

Улсын Их Хурлаас Геодези, зураг зүйн тухай хуулийг 1997 оны 10 дугаар сарын 31-ний өдөр 3 бүлэг, 15 зүйлтэйгээр баталсан бөгөөд геодези, зураг зүйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих, тэдгээртэй холбогдсон бусад харилцааг зохицуулах зорилготой байдаг.

Геодези, зураг зүйн тухай хууль анх батлагдсанаас хойш бусад холбогдох хууль шинээр болон шинэчлэн боловсруулагдсантай холбоотой нийт 11 удаа 15 зүйл, 41 хэсэг, заалтад нэмэлт өөрчлөлт орж, хоёр хэсэг нэмэгдсэн нь 123 заалт бүхий хуулийн 30 хувьд өөрчлөлт орсон байна.

Геодези, зураг зүйн салбар нь улсын хилийг тодотгон тогтоох, нутаг дэвсгэрийн хэмжээ, газрын гадаргын бодит байдал болон түүн дээрх обьектуудыг геодезийн өндөр нарийвчлал бүхий хэмжил зүйгээр орон зайн харилцаан байршилаар хэмжин зураглаж, байрлалд сууринсан орон зайн болон газрын зургийн тоон мэдээллээр батлан хамгаалах, газрын харилцаа, байгаль орчин, хөдөө аж ахуй, хот байгуулалт, барилга, эрчим хүч, зам, тээвэр, уул уурхай зэрэг нийгэм, эдийн засгийн бүхий л салбаруудын үйл ажиллагаанд ашиглагдах бүтээн байгуулалтын төлөвлөлтийн суурь мэдээллийг бүрдүүлдэг, улс орны батлан хамгаалах аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг хөгжлийн суурь салбар юм.

Геодези, зураг зүйн үйл ажиллагаа нь шинжлэх ухааны үндэслэл, тооцоотойгоор хийгддэг нарийн мэргэжлийн үйл ажиллагаа учраас шинэ техник, технологийн хөгжил дэвшлийг нэвтрүүлэх, тухайн асуудлыг эрхэлсэн төрийн институцийн бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн өөрчлөлт, холбогдох хууль тогтоомжид орсон өөрчлөлт, шинэчлэлтийг тусгах болон уг хуульд олон удаагийн нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан хуулийг зайлшгүй шинэчлэх шаардлага үүсээд байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт “2021-2030 онд ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангана” гэсэн зорилт тавьж, мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 3.6.1-т “Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гурав дахь хэсгийн 3.7.1.-т “Газрын харилцаа, хот байгуулалтын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хотуудын зэрэглэлийг тогтооно.” гэж тус тус заасан.

Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахдаа хөгжингүй орны хууль эрх зүйн орчныг судлахаас гадна Оросын Холбооны Улсын “Геодези, зураг зүй болон орон зайн өгөгдлийн тухай, мөн зарим хууль тогтоомжид өөрчлөлт оруулах тухай” хуулийн албан ёсны мэргэжлийн орчуулгыг ашигласан. Түүнчлэн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжийг судалж, холбогдох зүйл заалтуудыг уялдуулах, хуулийн шинэчилсэн найруулгын тесөлд тусгах шаардлагатай заалтуудыг нийцүүлэн тусгасан.

Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Барилга, хот байгуулалтын Сайдын 2017 оны 74, 2019 оны 156 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулагдаж, Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Геодези, зураг зүйн тухай

хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгааг хийж үзэл баримтлалыг 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Барилга, хот байгуулалтын сайд Хууль зүй, дотоод хэргийн сайд нар хамтран баталсан.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд тус хэлэлцүүлэгт холбогдох яам, агентлаг, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагууд, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагагын төлөөллүүд идэвхтэй оролцож, хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналаа өгсөн. Хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлтийг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан бөгөөд зарим нэг заалтад саналуудыг тусгахдаа холбогдох мэргэжлийн байгууллагуудаас тодруулга авч 6 бүлэг, 32 зүйл, 169 хэсэг, 236 заалттай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эцсийн хувилбарыг батлагдсан үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан.

Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд болон дагалдан гарах хуулийн төсөлд Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Засгийн газрын гишүүдээс болон холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагуудаас санал авч тусгасан.

Түүнчлэн геодези, зураг зүйн бүтээгдэхүүн болон хэмжилт, зураглалын ажлууд /төрийн болон албаны нууцыг агуулсан/ нь улс орныг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн байдаг тул хуулийн төсөлд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон Тагнуулын ерөнхий газраас санал авч, ирүүлсэн саналыг төсөлд тусган найруулсан бөгөөд нийт 23 байгууллагаас санал авч хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан байна.

Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг үнэлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох ажлыг зохих журмын дагуу зохион байгуулан боловсруулж, баримт бичгийн бүрдлийг ханггуулсан бөгөөд Барилга, хот байгуулалтын сайдын дэргэдэх зөвлөлийн хурлаар 2019 оны 12 дугаар сарын 3-ны өдөр хуулийн төслийг хэлэлцүүлсний дагуу хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд оруулан шийдвэрлүүлсэн.

Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, хуулийн төсөлд тусгасан зарчмын шинжтэй зохицуулалтууд:

Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ерөнхий агуулгыг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаанд үндэслэн уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд заасан 8 /найм/ агуулгын хүрээнд боловсруулсан.

Хуулийн төслийн зорилтоос эхлээд өнөөдөр энэхүү салбарт хэрэгцээ нь үүсэж, шаардагдаж байгаа дараах зохицуулалтуудыг хуулийн төсөлд шинэчлэн болон шинээр тусган хуульчилсан:

1. Хүчин төгөлдөр мөрдөгдэж байгаа хуулийн зорилтод төлөвлөх, болон санхүүжүүлэх гэсэн харилцааг шинээр тусгасан ба эдгээр зохицуулалтыг хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.2, 17 дугаар зүйлийн 17.1.1 дахь заалтаар шинээр тусган хуульчилсан;

2. Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаагаар Засгийн газрын зүгээс геодези, зураг зүйн талаар хэрэгжүүлэх бүрэн эрхэд геодези, зураг зүйн үйл ажиллагааны журмыг батлах, мөрдүүлэх үйл ажиллагаа зохицуулах шаардлагатай байгаа асуудлыг судалж, геодези, зураг зүйн үйл ажиллагаатай холбоотой зохих зүйл, хэсэг, заалтуудыг ангилан тусгасан. Жишээлбэл: хуулийн төслийн 19 дүгээр зүйл “19.1.1.геодези, зураг зүйн тухай хууль тогтоомжийн биелэлтийг харьялсан салбartaа зохион байгуулах; 19.1.2.салбарын хүрээнд дараа жил хийгдэх геодези, зураг зүйн ажлын саналыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны

байгууллагад тухайн жилийн 6 дугаар сарын 1-ний өдрийн дотор гаргаж өгөх; 19.1.3.өөрийн салбарт хийгдэх геодези, зураг зүйн ажлын техник эдийн засгийн үндэслэл, техникийн төсөл, ажлын даалгавар боловсруулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гүйцэтгэлийг хүлээн авах, норматив баримт бичгийг мөрдүүлэх ажлыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах; 19.1.4.салбарын төлөвлөлтийн зураг зохиох, салбарын орон зайн мэдээллийн сан байгуулахдаа геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн систем, үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцэд буй суурь газрын зураг, өгөгдөл, мэдээллийг ашиглах;" гэсэн заалтуудыг оруулсан нь одооны хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуульд болон бусад холбогдох хуульд тусгагдаагүй, уг салбарт нэн тэргүүнд шаардлагатай, тулгамдаад байгаа асуудал хуульчлагдаж байна;

3. Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан мэргэжлийн нэр томъёонуудыг тодорхойлж тусгасан/;

4. Геодези, зураг зүйн үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлсон /нийт 33 үйл ажиллагаа, хуулийн төслийн Хоёрдугаар бүлгийн 5 дугаар зүйлийн 5.1 дүгээр хэсэг/, мөн эдгээр үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх талаар хуулийн төслийн 5.2 дахь хэсэгт тусгасан;

5. Геодези, зураг зүйн зарим нэг үйл ажиллагааг, жишээлбэл Монгол Улсыг батлан хамгаалах зорилгоор хийгдэх геодези, зураг зүйн ажил, солбицол, өндөр, гравиметрийн тогтолцоо, геодезийн сүлжээ, геодезийн байнгын цэг, тэмдэгт, мөн газрын зургийн ангилал, зориулалт, төрлийг хуулийн төслийн Хоёрдугаар бүлгийн 6, 7, 8, 9, 10 дугаар зүйлд тус тус нарийвчлан тусгалаа. Геодези, зураг зүйн үйл ажиллагааны бүтээгдэхүүн байр зүйн зургийг /дунд болон том масштабын/ төрийн нууцын зэрэглэлтэй гэж өмнө нь ашиглах боломжгүй заасан байсныг нууц, нууц биш буюу нийтийн болон тусгай зориулалтын ангилалтай болгож хуулийн төсөлд тусгасан. Төрийн болон албаны нууцын жагсаалтад орсон мэдээлийг агуулсан зураг нь тусгай зориулалтын байх бөгөөд эдгээр мэдээллийг агуулаагүй бол нийтийн зориулалтын гэж ангилан оруулсан;

6. Геодези, зураг зүйн үйл ажиллагааны талаархи төрийн байгууллагын бүрэн эрх, чиг үүргийг тодорхой заасан. Жишээлбэл Геодези, зураг зүйн салбарын удирдлага, зохицуулалт, геодези, зураг зүйн үйл ажиллагаанд оролцогчийн чиг үүргийг тодорхой зааж, Улсын Их Хурлын бүрэн эрхийг хэвээр үлдээж, Засгийн газрын бүрэн эрхийн зохицуулалтыг өөрчилж, геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг нарийвчлан тодорхойллоо. Үүнээс гадна бусад төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагуудын оролцоог тодорхой зохицуулж, төрийн бус байгууллагын оролцоо, аймаг, нийслэлийн Засаг дарга геодези, зураг зүйн талаар хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхой тусгасан;

7. Газар зүйн нэрийн зохицуулалтыг нарийвчилж, шинээр зохицуулалт нэмж тусгасан бөгөөд өнөөгийн газар зүйн нэртэй холбоотой үүсээд байгаа асуудлыг Засгийн газрын түвшинд зохицуулахаар тусгалаа;

8. Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд тусгагдсан 8 агуулгын нэг болох геодези, зураг зүйн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх болон мэргэшлийн зэрэг олгох сургалт зохион байгуулах асуудлыг шинээр тусгасан;

9. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд геодези, зураг зүйн ажилд магадлал хийх иргэн, аж ахуйн нэгжийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, экспертийн эрх олгох нь геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт хамаарах бөгөөд магадлал, магадлан хэмжилт хийх, захиалагчийн техник хяналтын зохицуулалтуудыг нарийвчлан тусгалаа;

10. Түүнчлэн, төрийн бусад байгууллагын эрхэлсэн асуудалд хамаарахгүй хирнээ хийгддэг геодези, зураг зүйн үйл ажиллагааны зохицуулалтыг тусгаж, эдгээр ажлуудыг гүйцэтгэхдээ геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас суурь мэдээлэл авч ашиглаж байхаар, мөн газрын зургийг хэвлэхдээ тухайн асуудлыг хариуцсан төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авч хэвлэж байхаар уг хуулийн төсөлд тусгасан;

11. Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулагдах тул тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтыг тус хуульд нийцүүлэн хуулийн төсөлд тусгасан болно.

Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцэх бөгөөд 6 бүлэг, 32 зүйлтэй, хуулийн төсөлтэй холбогдуулан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хаягжуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол хэлний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Геодези, зураг зүйн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР